

## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

### ГҮЙЦЭТГЭЛ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН АУДИТОР ШАЛГАРУУЛЖ АВАХ ТУХАЙ

2025.01.07

**Албан тушаалын нэр:** Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын Аудитор

#### Албан тушаалд тавигдах ерөнхий шаардлага:

- Монгол Улсын иргэн байх;
- Дээд боловсролтой байх;
- Эрүүгийн хуульд заасан авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдэж шүүхээр ял шийтгүүлж байгаагүй;
- Сэтгэцийн өвчин, эмгэггүй;
- Хуулийн дагуу цэргийн жинхэнэ алба хаах үүрэг хүлээсэн иргэн үүргээ биелүүлсэн байх (эрэгтэй);
- Төрийн байгууллагад ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагч байх эсхүл, төрийн албаны ерөнхий шалгалт өгсөн, төрийн жинхэнэ албаны нөөцөд бүртгэлтэй байх.
- Албан тушаалын тодорхойлолтод заасан тусгай шаардлагыг бүрэн хангасан байх;

#### Албан тушаалд тавигдах тусгай шаардлага:

Боловсрол	Бакалавр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх.	
Мэргэжил	<ul style="list-style-type: none"><li>- Эрх зүй /042/;</li><li>- Нягтлан бодох бүртгэл /041/;</li><li>- Эдийн засагч /0311/;</li><li>- Санхүү /0412/.</li><li>- Иргэний ба үйлдвэрийн барилга байгууламж /073/;</li><li>- Инженерчлэл, инженерийн үйлдвэрлэл /071/.</li><li>- Олон улсын харилцаа /031202/</li></ul>	
Мэргэшил	Төрийн албанд мэргэшүүлэх эсхүл түүнтэй адилтгах сургалтад хамрагдаж төгссөн, Мэргэжлээрээ мэргэшсэн бол давуу тал болно.	
Туршлага	Мэргэжлээрээ 2-оос доошгүй жил ажилласан байх.	
	Дүн шинжилгээ хийх	<ul style="list-style-type: none"><li>- албан ажлын хэрэгцээнд шаардагдах мэдээлэл, судалгааг цуглуулж боловсруулах;</li><li>- мэдээлэл дэх дутуу, алдаатай, нийцтэй бус байдлыг илрүүлэх;</li><li>- судалгааны арга зүйн мэдлэгтэй байх;</li><li>- тулгамдсан асуудалд дүн шинжилгээ хийх, чадвартай байх;</li><li>- тоон болон чанарын судалгааг боловсруулах чадвартай байх;</li><li>- ажлын явц, гүйцэтгэлийн үр дүнг тооцох чадвартай байх;</li><li>- бусад.</li></ul>

Ур чадвар	Асуудал шийдвэрлэх	<ul style="list-style-type: none"> <li>- албан тушаалын чиг үүргээ хууль тогтоомж, ёс зүйн зарчимд нийцүүлэн ашиг сонирхлоос ангид хараат бусаар гүйцэтгэх;</li> <li>- аливаа асуудлыг гүйцэтгэхдээ эрсдэл тооцох чадвартай байх;</li> <li>- хуульд нийцсэн, оновчтой, үр дүнтэй шийдлийг боловсруулах;</li> <li>- үл ойлголцлыг эв зүйгээр зохицуулах;</li> <li>- бусдыг сонсох чадвартай;</li> <li>- гаргасан шийдвэрийнхээ үр дагаврыг хариуцах;</li> <li>- бусад.</li> </ul>
	Багаар ажиллах	<ul style="list-style-type: none"> <li>- өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж хамтран ажиллах;</li> <li>- бусадтай харилцан итгэл төрүүлэхүйц ажил хэрэгч, нээлттэй харилцааг бий болгох;</li> <li>- маргаантай асуудалд хүлээцтэй, нийцтэй ханддаг байх;</li> <li>- бүтээлч санаачилгатай ажиллах;</li> <li>- бусадтай ажил хэрэгч, нээлттэй харилцааг бий болгох;</li> <li>- ёс зүйн хэм хэмжээг сахиж, хувийн зан төлөв, зарчимч, тууштай, ажил хэрэгч чанар, бусдыг дэмжих, чиглүүлэх зэргээр үлгэрлэх;</li> <li>- багаар ажиллах, багийн амжилтыг үнэлэх, дэмжих, бусдад таниулах;</li> <li>- бусад.</li> </ul>
	Бусад	<ul style="list-style-type: none"> <li>- төрийн албан хэрэг хөтлөлт, бичиг хэрэг, монгол хэл, найруулга зүйн чадвартай байх;</li> <li>- англи хэл, эсхүл бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийг ашиглах чадвартай байх;</li> <li>- компьютерын хэрэглээний программ, мэдээллийн орчин үеийн технологи ашиглах;</li> <li>- үндэсний бичгийн хэлээр уншиж бичих чадвартай байх;</li> <li>- төрийн болон хувь хүний нууцыг хадгалах.</li> </ul>

### **Бүртгүүлэхдээ дор дурдсан бичиг баримтыг бүрэн ирүүлнэ. Үүнд:**

- Өргөдөл хүсэлт;
- Төрийн албан хаагчийн анкет;
- Иргэний үнэмлэхийн хуулбар;
- Боловсролын түвшнийг тодорхойлсон баримт бичгийн хуулбар (диплом) Хэрэв гадаад улсад их, дээд сургууль төгссөн бол боловсролын баримт бичгийн баталгаат орчуулгыг хавсаргах;
- Мэргэшүүлэх сургалтад хамрагдсаныг гэрчлэх баримт бичгийн хуулбар;
- Төрийн жинхэнэ албанд ажилласан тухай нотлох баримт бичиг /шалгалтад орж тэнцсэнийг нотлох баримт бичиг, тангаргийн хуудас/;
- Төрийн албаны ерөнхий шалгалт өгч, төрийн жинхэнэ албаны нөөцөд бүртгэгдсэн тухай баримт бичиг;
- Нийгмийн даатгалын дэвтэр (Хөдөлмөрийн дэвтэр)-ийн хуулбар эсхүл Цахим лавлагаа ("e-mongolia"- аас татан авах);
- Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх тухай тодорхойлолт (e-mongolia–аас татан авах);

- “4 х 6”-ийн хэмжээний цээж зураг 2 хувь

**Материал хүлээн авах хугацаа:**

Хүсэлт, холбогдох баримт бичгийг 2025.01.10-ны өдрийн 17:30 цаг хүртэл

**Материал хүлээн авах хаяг:**

Үндэсний аудитын газар,  
Тамгын газар  
Засгийн газрын 4-р байр, 3 давхарт 306 тоот

Холбоо барих утасны дугаар  
Үндэсний аудитын газар: 51-261585